

## Аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар

2023 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Суурь түвшин	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<b>2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>								
1	2.1.1. Нотолгоонд суурилсан оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	1. Анхан шатны 24 нэгжийн эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	2021-2024	-60	18.500.000	90	Сумын Эрүүл мэндийн төвд зайлшгүй шаардлагатай 46 тоног төхөөрөмжөөс 43-г нь лабораторийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байгаа буюу тоног төхөөрөмжийн хангалтын хувь 92% байна. 2023 оны I улиралд гематологийн бүрэн автомат анализатори, II улиралд ЭХО аппарат, III улиралд биохимийн анализатор, автоклав зэрэг тоног төхөөрөмжийг шинээр нийлүүлэн ашиглаж 398 хүнд үйлчилсэн байна.	100%
2	2.1.2. Эрэгтэйчүүдэд	1. Цэргийн насны 18-25 насны	2021	-200	-	200	Сумын хэмжээнд 2023 онд цэргийн насны 56 иргэнийг 6 төрлийн шинжилгээнд хамруулж эмчийн	90%

	чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэн, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулж, өвчлөлийг илрүүлж, эрүүлжүүлэх	2024				үзлэг шинжилгээ хийсэн. Үзлэг шинжилгээгээр 4 хуучин, 1 шинэ өвчлөлийг илрүүлж, эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Тэнцсэн 2 цэргийг цэргийн нэгдсэн эмнэлэгт цэргийн алба хаах хугацаанд эмчлэн эрүүлжүүлэхээр албанд татсан. Цэрэг татлагаар эрүүл мэндээр тэнцсэн 22 цэрэг цэрэгт явах болзол хангасан. 2 цэргийг дүйцүүлэх журмаар цэргийн албанд татсан болно. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөнд 8 ажил төлөвлөн хэрэгжүүлж 11 сарын 16-ны байдлаар дундаж биелэлт 81,6%-тай байна.	
3	2.1.3. “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	2. Сүрьеэ өвчний илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	2021-2024	-4.8	хөрөнгө зарцуулаагүй.	3.5	Элэгний хавдарын үзлэгт 2023 онд 65 хүн хамрагдсан. Ходоодны хорт хавдрын өвчлөл шинээр 1 бүртгэгдсэн хорт хавдрын нас баралт нас баралт бүртгэгдээгүй. Хорт хавдартай 8 хүн хяналтанд хянагдаж байна. Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт 256 хүн хамрагдахаас эхний хагас жилд 224 хүн хамрагдсан. Хамрагдалтын хувь-87,5 хувьтай Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд хяналтанд орж байгаа жирэмсэн эхчүүдийг 100 хувь В,С вирусын шинжилгээнд хамруулж байна. В вирус тэй 1 жирэмсэн эхийг хянаж аймгийн нэгдсэн эмнэлэгт төрүүлэн төрсөн нярайд В вирусын эсрэг иммуноглобулиныг хийлгэсэн. Зорилтот бүлгийн 65	100%

							хүн эхний хагас жилд В,С вирусын шинжилгээнд хамрагдсан шинээр В.С вирус илрээгүй. Харшлаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажилласан. Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт 175 хүн хамрагдаж 14 хүний 28 сорьцыг тээвэрлэн шинжлүүлсэнээс эерэг сорьц гараагүй. Сүрьеэ өвчний эрт илрүүлгийн асуумж үзлэгийг бүх жирэмсэн эхчүүдэд хяналтын хугацаанд 2 удаа хийж төрсөн нярай бүрт 24 цагийн дотор сүрьеэ өвчнөөс сэргийлэх БЦЖ вакциныг хийсэн. Сүрьеэ өвчин 1 бүртгэгдсэн аймгийн сүрьеэгийн тасгийн хяналтанд эмчлүүлсэн.		
4	2.2.2. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх	“Эрүүл, амьдрал” арга	2022 - 2024	0	941.000	100	Орон даяар хэрэгжиж байгаа Энэ жилдээ эрүүл жиндээ аяны төлөвлөгөө боловсруулан аяны нээлтийг 2023 оны 5 дугаар сарын 3 нд хийж нээлтэнд нийт 189 хүн оролцсон. Нээлтэнд оролцсон бүх хүмүүсийн жин өндөр БЖИ байх ёстой жинг тодорхойлон сургалт зөвлөгөө өгсөн. Нээлтэд оролцсон иргэдийн 27 хувь нь эрүүл жиндээ 73 хувь илүүдэл жин таргалалттай байна. Иргэдэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, хүнсний бүтээгдэхүүний шошго мэдээлэлийг ашиглаж, эрүүл хүнс сонгон хэрэглэх, давсны хэрэлээг бууруулах, хорт зуршлаас татгалзах, хүүхдийг 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох зэрэг сэдэвт сургалуудыг эмч мэргэжилтэнүүд явуулж давхардсан тоогоор 428 хүн хамрагдсан. Бие бялдараа хөгжүүлэх, бүжгийн дугуйланг Соёлын мэдээлэлийн төвөөс насанд хүрэгчид, цэцэрлэг сургуулийн хүүхдүүдэд хичээллэж нийт 38 иргэд , 50 хүүхэд хамрагдаж байна. Долоо хоногийн бүрийн пүрэв гаригыг Соёл мэдээлэлийн төвөөс бүжгийн өдөр болгон зарлаж аж ахуй нэгж, албан байгууллагууд ээлж дараагаар	100%

							шугаман бүжиг зааж байна. Мөн 2 ахмад аймагт 14 хоногийн бүжгийн сургалтанд суралцаж ирээд Ахмадын өргөөнд ахмадуудад бүжиг зааж байнгын идэвхтэй хөдөлгөөн хийж байна.	
5		2. Спорт заалуудын ашиглалтыг сайжруулах	2021 2024	-20000	хөрөнгө зарцуулаагүй.	20000	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл сургалтын үйл ажиллагааг тогтмол явуулж байна. Мөн төрийн байгууллагууд хуваарийн дагуу чийрэгжилт хийж байна. Сургуулийн 80 жилийн ойг угтсан волейболлын тэмцээн, малчдын дунд зохион байгуулагдсан спортын олон төрөлт тэмцээн уралдааныг зохион байгуулж ажилласан.	100%
6		3. Заал, талбайн засвар үйлчилгээ хийж, шинээр ашиглалтад оруулах	2021 2024	-2 0 0	2,000,000	2 1 0	2022 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр заалны засвар үйлчилгээг хийсэн. 2023 онд Ерөнхий боловсролын сургууль өөрийн хөрөнгөөр үзэгчдийн суудал, дуу намсгагч зэрэг засвар үйлчилгээнүүдийг хийсэн.	100%
7	2.3.2. Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ.	1. Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг чадваржуулах сургалтад хамруулах	2021 2024	-96	улсын төсөв	40	Тусгай хэрэгцээт боловсролын 7 сурагч өдрийн ангид суралцдаг. Бага боловсролыг 6 сурагч, суурь боловсролыг 1 сурагч амжилттай төгссөн. Улсын хэмжээнд зохион байгуулсан тусгай хэрэгцээт боловсролын сурагчдад “Сайн туршлагын эмхэтгэлийг боловсруулах” арга хэмжээнд МХУЗ-ын багш Д.Бямбасүрэн амжилттай оролцож улсын хэмжээний сургагч багш болсон. Чадавжуулах сургалтад 2 багш хамрагдсан.	90%
8	2.3.3. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд	3. 5 настай хүүхэд бүрийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах	2021 2024	-97	-	100	2023-2024 оны хичээлийн жилд өдрийн бүлэгт 225, хувилбарт сургалтаар 75 нийт 300 хүүхэд СӨБ олгож байна. 5 настай 80 хүүхэд байгаагаас 74 хүүхэд өдрийн бүлэгт, 6 хүүхэд хувилбарт сургалт буюу явуулын багшийн сургалтад хамрагдаж байна. Хамран сургалтын хувь 88,2 хувьтай байна.	90%

	бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ.							
9	2.3.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ.	1. Тэгш хамран сургах дүйцсэн хөтөлбөр, бичиг үсгийн сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх	2021-2024	-250	хөрөнгө зарцуулаагүй	650	Боловсрол нөхөн олгох хөтөлбөрт бага ангид 2 сурагч, дунд ангид 8 сурагч ахлах ангид 17 сурагч нийт 27 сурагч хамрагдаж байна. Хичээлийн жилээр хөтөлбөр төлөвлөгөө гарган хуваарийн дагуу мэргэжлийн багш нараар хичээлийг холимог бүлгээр хичээллүүлсэн. Сумын хэмжээнд бичиг үсгийн боловсролын судалгаа авч үе шаттайгаар сургалт хийсэн. Нийт 8 сурагч хамрагдсан. Сургалтыг 30% танхим 70% бие даалт байна.	100%
10		2. Насанд хүрэгчдийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх	2021-2024	-5000 0	хөрөнгө зарцуулаагүй.	15000 2	Санхүүгийн боловсрол 3 удаа 68 иргэнд, гэр бүлийн боловсрол 3 удаа 64 иргэнд, гоо зүйн боловсрол 4 удаа 107 иргэнд, ёс суртахуун, төлөвшлийн сургалтыг 3 удаа 79 иргэнд, амьдрах ухааны боловсрол 2 удаа 15 иргэнд, мэдээлэл харилцаа 2 удаа 24 иргэнд, өрхийн хөгжил арга хэмжээ 4 удаа 38 иргэнд нийт давхардсан тоогоор 395 иргэнд сургалт мэдээллийн арга хэмжээ зохион байгуулсан байна. Сургалтад хамрагдсанаар олон талын анхан шатны мэдлэгтэй болж амьдрал ахуйдаа хэрэгжүүлэх боломжтой болсон	100%
11	2.6.1. Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад	1. Түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалтыг сайжруулах	2021-2024	-10	-	8	Сумын хамгаалалтад байдаг ТСҮХД 27 газрыг Соёлын төвийн дарга, багийн Засаг дарга, малчидтай гурвалсан гэрээг 100 хувь хийсэн. Хариуцан хамгаалж байгаа малчдыг соёлын үзвэр үйлчилгээнд үнэ төлбөргүй оруулж урамшуулан ажилласан. Мөн дурсгалын хүүхэд залуучуудад түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол ухаан” хөтөлбөрийн хүрээнд 5-р ангийн нийт 71-н сурагч 36-н эцэг эх 4-н багш түүхэн дурсгалт “Цагаан агуй”,	100%

	түгээн дэлгэрүүлэн сурталчилна.						8-р ангийн нийт 64-н сурагч 9-н эцэг эх 4-н багш “Бичигт хад”, 9 дүгээр ангийн 63-н сурагч 7-н багш Өмнөговь аймгийн Сэврэй сумруу явж тухайн орон нутгын түүхэн дурсгалт газруудтай танилцуулсан. Аялалд явснаар сурагчид сум орон нутгийн түүхэн дурсгалт газартай танилцах, эх орноо хайрлах сэтгэлтэй болж, байгальд аялах соёлд суралцсан.	
12	2.8.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн байна.	1. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх	2021-2024	-3.2	-	25	Байгууллагуудын эцэг эхийн зөвлөлүүд болон багийн Засаг дарга нартай хамтран төрийн албан хаагчид болон ард иргэдийг угийн бичиг хөтлөх уриалга гарган, угийн бичиг хөтлөх арга зүйн талаар багийн иргэдийн нийтийн хурал болон албан байгууллагуудад сургалт хийж ажилласан. Сургалтад 253 хүн хамрагдсан. Уриалгын хүрээнд ЗДТГ 28-16 албан хаагч буюу 57.8%, ЕБС 74-27 албан хаагч буюу 36,4%, Эрүүл мэндийн төв нь 31-12 албан хаагч буюу 38.7%, СӨБ 21-12 албан хаагч буюу 57,1%, Соёлын төв 6-2 албан хаагч буюу 33.3% нь угийн бичиг хөтөлсөн үр дүнтэй байна.	70%
<b>3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>								
13	3.1.4. Тунгалаг санхүү хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2. Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагналт, баталгаажуулалтын хувийг нэмэгдүүлэх	2021-2024	-80	-	83	Сумд бүртгэлтэй 35 аж ахуйн нэгж, хоршоод нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргасан. "E-balance.gov.mn" системд жилийн эцсийн санхүүгийн тайланг шивэхэд хяналт тавин ажилласан.	100%
14		3. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн	2021-2024	-40	-	53	Сумд бүртгэлтэй 41 аж ахуйн нэгж, хоршоо, төрийн бус байгууллага байдаг. Үүнээс тогтмол үйл ажиллагаа явуулдаг 8 аж ахуйн нэгжээс санхүүгийн тайлангийн программыг ашигладаг 4, “excel” файл ашиглан орлого зарлагаа тооцон санхүүгийн тайлангаа гаргадаг 4 ААН байна. Энэ онд үйл	100%

		программыг нэвтрүүлэх					ажиллагаагаа эхэлсэн 3 ААН одоогоор санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлээгүй. Бусад 30 аж ахуйн нэгж, хоршоо, төрийн бус байгууллагууд нь үйл ажиллагаа явуулдаггүй учир санхүүгийн программын шаардлага байхгүй байна. Тунгалаг санхүү хөтөлбөр хэрэгжиж дууссан. Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувьтай.	
15	3.3.5. Эвдэрсэн газрын тооллого судалгаан дээр үндэслэн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.	1. Аймгийн хэмжээний эвдэрсэн газрын тооллого, судалгаанд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах	2021-2024	-0	-	15	Тус суманд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар байхгүй болно.	100%
16	3.6.1. Мал сүргийн шилэн сонголтын ажлыг сайжруулж, малын ашиг шимийн түвшинг нэмэгдүүлж, малчдын мэдлэгийг дээшлүүлнэ.	1. Малын шилэн сонголтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглан ашиг шимийг нэмэгдүүлэх	2021-2024	-40	Ламын гэгээний улаан тэмээний үүлдэр батлуулах ажилд 16,129,050 төгрөг, Баянбулаг омгийн хурган хуц авч ирэхэд замын зардал 1.237.500 төгрөг зарцуулсан.	70	Тус сумын Ламын гэгээний улаан тэмээ нь үржлийн хэсгээр батлагдсан ба үүлдэрээр баталгаажуулах ажил үе шаттай хийгдэж байна. Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн А/220 тушаалаар томилогдсон ажлын хэсэг, аймаг, сумын мэргэжлийн байгууллагын төлөөлөл, сумын удирдлагууд, албан хаагчид, малчидтай хамтран “Цөм сүргийн 6 малчны үржлийн төрөл бүрийн нас хүйсний 57 тэмээнд хаврын амьдын жин, ноосны дээж авч биеийн үндсэн хэмжээг авч ашиг шимийн дундаж гарцыг тодорхойлов. 2 малчны 20 ингэнд хяналтын саам хийж гүйцэтгэсэн. 2023 оны 10 дугаар сард УИХ-ын даргын санаачлагаар Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Баянбулаг омгийн хурган хуц 25-ийг авч үржилд ашиглан ашиг шимийг нь нэмэгдүүлэн ажилласан.	90%
17		3. Малчдын мэдлэг,	2022	-0	4.680.000	100	Малчид, төлчдийн зөвлөгөөнийг 03 дугаар сарын 11-	100%

		мэдээллийг нэмэгдүүлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	2024				ний өдөр зохион байгуулж малчдад Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулиас холбогдох мэргэжилтнүүд, эмч, багш нар оролцож 200 гаруй малчдад сургалт зохион байгуулсан. Мөн малчдын дунд Шагай наадгай, Гар бөмбөгийн тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулсан. Мөн багийн иргэдийн Нийтийн хуралд мэргэжилтнүүд оролцож сургалт мэдээлэл өгсөн. Нийт 157 малчин хамрагдсан.	
18	3.6.2. Мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл статуса бататгана.	1. Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, угаалга туулгалтад мал сүргийг хамруулах	2021-2024	-3	улсын төсөв, 2 шатахуунд Засаг даргын Тамгын газраас 1600000төгрөг		Сумын хэмжээнд 81022 малыг халдварт өвчнөөс урьчилан сэргийлэх вакцинд хамруулахаар Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч А.Элдэв-Очир мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөж оруулсан. Баянлиг түмэн тэмээ мал эмнэлэг 6 төрлийн вакцинд 17686 толгой мал хамруулахаас 17367 толгой мал хамруулж гүйцэтгэл 98.20%, Баянлиг буянт сүрэг мал эмнэлэг 6 төрлийн вакцинд 27173 толгой мал хамруулахаас 26130 толгой мал хамруулж гүйцэтгэл 96.16%, Хар ботго мал эмнэлэг 8 төрлийн вакцинд 36163 толгой мал хамруулахаас 35932 толгой мал хамруулж гүйцэтгэл 99.36%-тай байна. Сумын хэмжээнд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 167757 толгой мал хамруулахаас 163290 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 97.34%тай хэрэгжүүлж ажилласан байна. Мөн гоц халдварт шүлхий өвчний вакциныг хавар, намрын давтамжтайгаар 2 удаа хийж гүйцэтгэсэн. Шатахууны зардалд Засаг даргын Тамгын газраас 1,600,000 төгрөг зарцуулсан.	100%
19		2. Мал эмнэлгийн бүртгэл мэдээллийн системийн ашиглалтыг	2021-2024	-0	-	7000	Мал эмнэлгийн нэгдсэн систем шинэлэгдэж Баянлиг түмэн тэмээ, Хар ботго, Баянлиг буянт сүрэг мал эмнэлгүүдийг системд бүртгэсэн. Малаас гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нийт 59 гэрчилгээ бичиж баталгаажуулан хяналт тавиж ажилласан. Ноолуур	100%



		сайжруулж, мал болон малын гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавих					13 тн, арьс шир 300 ширхэг, сүү цагаан идээ 230 литр, амьд мал 143 толгой тус тус бичигдсэн.	
20		3. Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шаардлагатай эм, бэлдмэл, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх	2021-2024	-0	3,000,000	15	Мал эмнэлгийн үйлчилгээнд зориулж ариутгалын бодис, 200 кг хлорын шохой, нэг удаагийн мал эмнэлгийн хувцас 10 ширхэгийг нөөцөд бүрдүүлэн мал эмнэлгийн үйлчилгээнд ашиглаж байна.	100%
4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
21	4.3.5. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.	1. Авлигын гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, шударга байдлын төвшинг нэмэгдүүлэн, цахим хуудасны ил тод байдлын төвшинг ахиулах	2021-2024	-5 70-45.8		2 72 48	Авлигын эсрэг төлөвлөгөө боловсруулан, албан хаагчдаар авлигаас ангид байх баталгааг гаргуулж гарын үсэг зуруулсан. Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай байна. Албан ёсны цахим хуудасны мэдээллийг тухай бүр нь шинэчилж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд ил тод байлгах аар заасан мэдээллийн 90 хувийг нь цахим хуудсандаа байршуулсан. Авлигын гэмт хэрэг бүртгэгдээгүй.	90%
22	4.5.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдэд эрх зүйн	1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, иргэдийн эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх	2021-2024	-1000	-	1600	Бүх нийтийн эрх зүйн боловсролын дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд төсөвт байгууллагын албан хаагчид болон багийн ИНХ, Баялаг бүтээгчдийн үзэсгэлэн худалдаа зэрэгт шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж болон Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 256 иргэнд хүргэсэн.	90%

	харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлнэ.							
23	4.6.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулна.	2. Төрийн болон байгууллагын архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах.	2021 2023	-183 13	-	70,0	2001-2022 оны түр болон 70 жил хадгалах баримт, 2021, 2022 байнга хадгалах баримтуудыг бор кордонаар үдэж, баримтын хамгаалах хайрцагт хийж нягтруулсан шүүгээ болон төмөр тавиурт хадгалж байна. Засаг даргын Тамгын газар нь нягтруулсан шүүгээ 2, ЕБС 2 нягтруулсан шүүгээтэй, Эрүүл мэндийн төв 4 нягтруулсан шүүгээтэй .Камер байхгүй  Хавсралт : 6 зураг	90%
24	хамгаалалт аюулгүй байдлыг сайжруулна.	3 . Төрийн болон байгууллагын архивын баримтын цахим санд шилжилтийг эрчимжүүлэх.	2021 2024	-77,4	2,051,000	86	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, Цахим архив-Баянхонгор дэд хөтөлбөрийн хүрээнд байгууллагын 2020 оны байнга хадгалах 142 хадгаламжийн нэгжийн 2280 хуудас баримт, нэмэлтээр тушаагдаагүй байсан 2015 оны 116 баримтын 1630 хуудас, 2016 оны 93 баримтын 1401 хуудас, 2017 оны 89 баримтын 1360 хуудас нийт 440 хадгаламжийн нэгжийн 6671 хуудас баримтыг аймгийн Төрийн архивын тасагт дансны хамт, цахим хувь үүсгэн хүлээлгэн өгсөн.  Хавсралт : 5 зураг	100%
25		4. Төрийн болон байгууллагын архивын баримтыг сэлбэн засах.	2021 2024	-0	-	0,22	Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/569 дугаар захирамжийн дагуу нэгдсэн тооллогыг бүх албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж баримтын хуудас нэг бүрийг тоолж, “Тоолов” тэмдэглэгээг хийж, гарын үсэг, тамга тэмдэгийн дутуу бүрдлийг хангаж 2001-2022 оны түр хадгалах баримтын бүртгэлийг засаж шинээр	100%

							<p>үйлдсэн. Баримтын нэгдсэн тооллого нь баримтын тоо мэдээг үнэн зөв бодит болгох, цэгцлэх чухал үр дүнтэй ажил болсон.</p> <p>Хавсралт : 2 зураг</p>	
<b>5. ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>								
26	5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ.	2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 20 сая мод тарих	2021-2024	-24268,88	-	50000,50	<p>Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны хаврын тариалалтаар 10 төрлийн 1750 мод, 3 га газарт заг сухайн үр 1250 шинээр тарьсан. 2023 онд нийт 3000 мод өөрсдийн эзэмшил талбайд тариалсан бөгөөд 150 иргэн буюу 74 өрх айл, 12 аж ахуйн нэгж байгууллага оролцсон. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2023 онд тарьсан мод тооллого ургалтын хувийг тогтоох ажлыг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж модны ургалтын хувийг тогтоосон. 2021-2023 онд нийт 35600 мод тарьснаас 32800 мод ургасан. Ургалтын хувь 92,1 хувьтай байна.</p> <p>Хавсралт : 3 зураг</p>	100%
27	5.2.1. Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв	1. Булгийн эхийг хамгаалж, ундаргыг сэргээх, хөв байгуулах	2021-2024	-6	-	3	<p>Баян-Аараг 2 дугаар багийн нутаг Хатавч, Бударгын булгуудын эх ундрагыг сэргээн засварлаж, булгийн эхийг тойруулан хамгаалалт хийсэн бөгөөд зэрлэг амьтад уух боломж нөхцөлийг сайжруулсан.</p>	90%
28	байгуулах ажлыг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.	2. Малчид, нөхөрлөлүүдтэй хамтран байгаль орчноо хамгаалах нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулах	2021-2024	-400	-	150	<p>Малчид болон иргэд аж ахуйн нэгж байгууллагыг оролцуулан сумын Засаг даргын 5 удаагийн захирамжаар 17 аж ахуйн нэгж байгууллага, 6 төрийн байгууллага, давхардсан тоогоор 215 иргэнийг оролцуулан 10.1 тонн бүхий хог хаягдлыг түүж цэвэрлэсэн. Мөн малчидтай хамтран зэрлэг амьтдыг хамгаалах, гар аргаар алт олборлохоос урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулсан.</p>	70%

29	5.2.2. Зэрлэг амьтдыг хамгаалах тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулна.	1. Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах	2021 - 2024	-2	-	3	Энэ жилийн хувьд зэрлэг амьтад биотехникийн арга хэмжээ авах хүнд нөхцөл үүсээгүй болно.	100%
30	5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана.	1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2021 - 2024	40	-	70	Жил бүрийн 03 дугаар сарын 22 ний өдрийг Дэлхийн усны өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан сумын эрүүл мэндийн төвтэй хамтран төрийн албан хаагчид болон Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад " Хуванцар сав ба түүний хэрэглээ", Усны зөв зохистой хэрэглээ сэдвээр сургалт зохион байгуулсан. Харзтай гол орчмын хог хаягдлыг төрийн байгууллагын оролцоотой түүж 2 тонн хогийг хогийн цэгт хүргэж ажилласан. Ундны ус авдаг 2 худгийг усны дээжийн шинжилгээнд хамруулж ажилласан.	100%

.....oOo.....